



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын  
3 дугаар сургуулийн бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шинэ зууны эрдмийн өргөө” ТББ-аас хандивласан нийт 17,920,000 (арван долоон сая есөн зуун хорин мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль (В.Хоролгарав)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль (В.Хоролгарав)-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2023 оны 04 дугаар сарын 25 өдрийн  
А/192 дугаар тушаалын хавсралт



**Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт**

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт	Ашиглалтад орсон огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага		
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр	
Тавилга, эд хогшил											
1	Сурагч ширээ, сандал	Модон тавцан, төмөр хөлтэй	2023	Сайн	ш	64	280,000	17,920,000	Шинэ зууны эрдмийн өргөө ТББ	Хандив	
Тавилга, эд хогшлын дүн									<b>17,920,000</b>		
Бүртгэх хөрөнгийн дүн									<b>17,920,000</b>		